

## **ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ**

Ms.Халиунаа санаачлан хөөцөлдөж H1N1 вирусын эсрэг вакциныг манай сургуулийн сурагчдад үнэгүй тариулсанд талархал илэрхийлье. Олон эцэг эхчүүд хүүхдүүддээ энэ вакциныг тариулсандаа баяртай байгаа.

Энэ долоо хоногт 2-р ангийн сурагчид Оюун Ухааны Музей үзэж, 6-р ангийн сурагчид гэр хороололд хичээлээс гадуурх аялал зохион байгууллаа. Сурагчид маань нийгмийн амьдралын олон салбарын талаар судалж байгаа бөгөөд та бүхэн өөрсдөөс нь энэ долоо хоногт сургууль дээр зохиогдсон ажлууд болон тэдний сурч мэдсэн зүйлсийн талаар асууж ярилцаарай.

Би Улаанбаатарт ирэх долоо хоногийн эхээр эргэж ирнэ. Та бүхэн Сар Шинэдээ Сайхан Шинэлээрэй!

**Захирал Greg Rayl**

### **ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:**

2 сарын 15,16	Цагаан Сарын Амралт-Хичээл орохгүй
2 сарын 18	Дунд Сургуулийн Эцэг Эх-Багш нарын хурал
2 сарын 23	ЭББ-ийн хурал 19:00 цагт
3 сарын 5	Бага Сургуулийн сурагчид кино үзнэ
3 сарын 18	Бага Сургуулийн сурагчдын жүжигчилсэн тоглолт

Цагаан Сарын Баярт зориулсан Өдөрлөг амжилттай болж өнгөрлөө. Монгол орны соёл заншлаас их зүйлийг сурч мэдэх сайхан боломжийг энэ арга хэмжээ бидэнд олгодог. Өдөрлөгийг амжилттай зохион байгуулсан Цагаан Сарын комиссийн гишүүдэд болон бидэнд сайхан тоглолт сонирхуулсан сурагчиддаа баяр хүргэе! Манай Өдөрлөгт ирж оролцсон эцэг эхчүүддээ баярлалаа.

Та бүхэндээ Бар жилдээ аз жаргал, амжилт бүтээлээр дүүрэн байхыг хүсэн ерөөе!

**Дэд Захирал Туул Арилдий**

### **ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

Цагаан сараар 4 хоног амарна. Энэ амралтын өдрүүддээ өвдөхгүй, болгоомжтой байгаарай. Цагаан Сарын дараа цаг агаар дулаардаг гэж би сонссон дулаарах байх гэж найдаж байна. Өглөө болгон сургуульдаа ирж байгаа сурагчдаа гадаа хүлээн авч мэндлэхэд нэлээд хугацаанд их хүйтэн байлаа.

10-р ангийн сурагчид маань бие дааж хийх төслийн ажлаа цагаан сарын дараа дуусгаж хамгаалах ёстой. Та бүхэн хүүхдүүддээ тусламж хэрэгтэй бол дэмжлэг үзүүлээрэй. 10-р ангийн сурагчдын хувьд энэ бие дааж хийх төсөл хамгийн чухал ажил байдаг. Өөрсдийн сонгож авсан сэдвийн хүрээнд төслөө хийх явцдаа сурагчид маань их олон зүйлд суралцдаг.

Багш нар маань төгсөх ангийн сурагчдаа 5 сард болох төгсөлтийн шалгалтанд нь бэлтгэж бусад сурагчиддаа өөрсдийн бүрэн боломжоо дайчлан суралцахад нь тусалж завгүй ажилласаар байна. Та бүхэн ч гэсэн гэртээ хүүхдүүддээ дэмжиж ажиллаарай. Бидний хамтын ажиллагааны үр дүнд сурагчид маань сайн суралцах болно.

Та бүхэнд сурагчдын эрүүл мэндийн талаар дахин сануулж хэлэхэд хүүхдүүддээ ус сайн уулгаарай. Сүүлийн үед олон сурагчид толгой, гэдэс өвдлөө гэж зовиурлах боллоо. Энэ нь шингэн дутагдсанаас болж элбэг тохиолддог шинж тэмдгүүд юм. Сурагчдын хувьд эрүүл байх нь хамгийн чухал. Та бүхэн тэдэнд өвдөхгүй байхад нь сайн туслаарай.

Сар Шинийн Мэнд Хүргэе!

**Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann**

### **Сурагчдын Зөвлөлөөс**

Сурагчдын Зөвлөл 2 сарын 19-нд хувцасныхаа дотрыг гадагш нь эргүүлж өмсөх өдөр зохион байгуулна. Сургуулийн орчинд зохицуулж та бүхэн энэ өдөр хувцсаа дотрыг нь гадагш нь эргүүлж өмсөөрэй.

## **Дунд ангийн сурагчдын Lock-In өдөр**

Сурагчдын Зөвлөл 2 сарын 20-ны Бямба гарагийн орой 8 цагаас 21-ний өглөөний 8 цаг хүртэл дунд ангийн сурагчдын сургууль дээр өнжих өдрийг зохион байгуулна. Сурагчид өөрсдийн тоглоом, хоол унд, мешокоо авчирч болно. Хэрвээ мөнгө авчрах бол их мөнгө авчрах шаардлагагүй гэдгийг сурагчдад сануулаарай.

Сурагчдын Зөвлөл оройн хоолонд пицца, өглөөний цайнд синнамон ролл өгнө. Арга хэмжээний үеэр бэлэн гоймон, ундаа, хөнгөн зууш худалдана. Сурагчид кино үзэж, видео тоглоом тоглож, спортын тэмцээн зохионо. 2 сарын 21-ний Бүтэн Сайны өглөө 8 цагаас хоцролгүй ирж хүүхдүүдээ аваарай. Энэ арга хэмжээнд олон сурагчид оролцоно гэдэгт бид итгэлтэй байна. Та бүхэнд баярлалаа.

**Сурагчдын Зөвлөл**

## **БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

### **CHARLIE AND THE CHOCOLATE FACTORY KG-G5 3 сарын 18-ны Пүрэв Гаргаг**

Бага сургуулийн хамт олон тоглолтондоо бэлтгээд бүгд завгүй ажиллаж байна. Бидний жүжгийн тоглолтын бэлтгэлд болон хувцаслалтанд тусалж байгаа эцэг эхчүүдээ маш их баярлалаа. Хэрвээ та бүхэнд тоглолтын талаар асууж лавлах зүйл байвал хүүхдийнхээ ангийн багштай холбоо бариарай.

Бидэнд яаралтай литрийн усны сав, хуванцар савнууд, гал тогооны болон нойлын цаасны дамрууд, чипсний хоосон савнууд хэрэгтэй байна. Та бүхэн эдгээр зүйлсийг зургийн тэнхимд болон хүүхдийнхээ ангид авчирч өгч болно.

Хичээлээс гадуурх аялалууд: 2-р ангийн сурагчид Лхагва гарагт Оюун Ухааны Музейг үзэж сонирхлоо. Тэд газрын татах хүч болон бусад хүчнүүд бусад биетэд хэрхэн үйлчилдэг талаар судалж энгийн машин, тоглоом хийхэд хүчийг хэрхэн ашигладаг талаар сурч мэдэж өөрсдөө туршилт хийж үзсэн.

Цагаан Сар: Цагаан Сард зориулсан Өдөрлөгийг амжилттай зохион байгуулсан комиссийн гишүүддээ болон тоглолтоо сонирхуулсан сурагчиддаа баярлалаа. Бага сургуулийн сурагчид Сүнгэрэлийн дуулахыг дахин сонссондоо баяртай байна. Сүнгэрэл Соёл Урлагийн Их Сургуулийн оюутан бөгөөд түүний сургалтын зардлыг 5-р ангийн сурагчид ивээн тэтгэдэг.

Та бүхэн Сар Шинэдээ Сайхан Шинэлээрэй!

**Бага Сургуулийн Эрхлэгч Jan Wiggins**

## **БИЕЙН ТАМИРЫН ТЭНХМЭЭС**

ОУДС –ийн сагсны баг тамирчид өнгөрсөн долоо хоногт Бээжингээс хэд хэдэн цомтой ирлээ. 1 сарын 27-нд Улаанбаатараас Бээжин ниссэн МИАТ-ийн онгоц цагтаа бууж бид Бээжингийн онгоцны буудлаас зочид буудал руу очиж үдийн хоол идэж ойролцоох дэлгүүрт орж худалдан авалт хийлээ. Орой нь буудалдаа очоод дараа нь Бээжин хотын олон улсын дунд сургууль (BCIS) дээр бэлтгэл хийгээд оройн хоолондоо орж дэлгүүр сонирхлоо.

Хөвгүүдийн баг эзэн багийн эсрэг тоглож 3 онооны зөрөөтэй хожигдлоо. Охидын баг бас эзэн багтай тоглож 21:16-н харьцаатай хожсон. Дараагийн тойрогт хөвгүүдийн баг Access International Academy Ningbo (AIAN)-н багийг, охидын баг Hong Kong Academy (HKA)–н багуудыг тус тус хожлоо. Тоглолтын дараа сурагчид байрлах айлууддаа хуваарилагдаж очлоо.

Баасан гарагт тамирчид маань бүтэн өдөржин тоглолттой байж тэмцээн болгондоо ялалт байгууллаа. QISS, SCISHZ, HKA, AIAN – сургуулиудын багууд манай охид хөвгүүдийн багт бүгд хожигдсон. Дараагийн өдөр нь манай тамирчид хагас шигшээ тоглолтонд шалгарч хөвгүүдийн баг SCINZ-н багтай, охидын баг QISS-н багтай тус тус тоглосон.

Хөвгүүдийн хагас шигшээ эхний тоглолтонд BCIS QISS-н багийг хожсоноор ОУДС-ийн хөвгүүдийн баг SCINZ багийг хожвол шигшээ тоглолтонд аль багтай тоглох нь тодорхой боллоо. Хөвгүүд нэмэлт цаг тоглож SCINZ-н багийг хожсоноор шигшээ тоглолтонд шалгарч үлдлээ. Охидын багийн хувьд QISS-н багийг хожсоноор шигшээ тоглолтонд түвэггүй шалгарч үлдсэн.

Харамсалтай нь хөвгүүд өмнөх тоглолтонд сайн тоглосон шигээ тоглож чадалгүй BCIS-н багт хожигдсон. Хэдийгээр тойргийн тоглолтонд охидын баг аваргын төлөө өрсөлдсөн багаа хожиж байсан ч эсрэг баг даагаа нэхэж сайн тоглоно гэдгийг мэдэж байсан. Үнэхээр ч SCINZ хамгаалалт сайтай тоглож тэмцээний аваргаар тодорлоо.

ОУДС-ийн охид, хөвгүүдийн баг 2-р байр эзэлж тэмцээний хаалтын ажиллагаан дээр цомоо гардаж авсан. Сурагчид тэмцээнд багаараа сахилга бат, зохион байгуулалт сайтай оролцож амжилт гаргалаа. Охидын баг шилдэг багаар шалгарч цом гардан авсан. Бүх оддын багт Vasek, Jiri, Derryn, Сарантөгс, Нiba, Байгаль нар шалгарсан.

АСАМIS-н тэмцээнд амжилттай оролцох нь чухал боловч энэ тэмцээний үеэр сурагчид олон найз нөхөдтэй болж бусдын соёл, зан заншлаас суралцах сайхан боломжийг олж авдаг юм. АСАМIS-н тэмцээн нөхөрсөг, өрсөлдөөнтэй болдог бөгөөд ОУДС-ийн сурагчид энэ тэмцээнд онцгой хувь нэмэр оруулдаг. Мэдээж хэрэг манай дасгалжуулагч багш нарын байнгын зөвлөгөө, туслалцаагүйгээр тамирчид амжилт гаргахгүй нь ойлгомжтой. Багаа сайн дасгалжуулж амжилтанд хүргэсэн дасгалжуулагч багш Mr. Mewbourn, Ms. Lohman нарт баяр хүргэе!

Дугуйлангийн талаар:

3-р улирлын дугуйлангууд хичээллэж эхлээд байна. Зарим дугуйланд бид нэмж хүүхэд бүртгэнэ. Үүнд:

#### **Мягмар гарагт**

1. Finger Food for G6-12 and now open for G-5 students as well
2. Fabric Collage for G7-12 and now open for G-6 students as well
3. History and Movie for G10-12 and now open for G-8 and 9 as well
4. Recorder Club for Grades 1-5

#### **Лхагва гарагт**

1. Paint and Print for G3-5
2. Party Handbags for G4-7
3. Magic Balloons for G6-12 and now open to G4,5
4. Pool and Table Tennis for G6-12
5. Embroidery for G4-7

Хэрвээ та бүхэн эдгээр дугуйланд нэмж бүртгүүлэхийг хүсч байвал Mr. Ricketts-тэй уулзаж зөвшөөрлийн хуудас авч бөглөнө үү.

#### **Пүрэв гарагт**

1. Karate for G4,5
2. Korean Essay for G10-12
3. Photography for G6-12

#### **Баасан гарагт**

Circuit Training for G6-12 (7.00AM )

**Биеийн Тамирын Тэнхмийн Эрхлэгч David Ricketts**